



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2016.06.20 № 31

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.23 дахь хэсэгт "Үндэсний үйлдвэрлэл хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ", 2.5 дахь хэсэгт "Томоохон төслийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ", 2.71 дэх хэсэгт "Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана", 2.72 "Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ", 2.73 "Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ", 2.112 дахь хэсэгт "Тавантолгой-Гашуун сухайт", "Хөөт-Бичигт" чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна", 2.113 дахь хэсэгт "Тавантолгой-Гашуун сухайт" чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, "Шивээ хүрэн-Сэхэ" чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана" гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эдийн засгийг сэргээх хөтөлбөр"-ийн 1.2.2-д "Эдийн засгийн бодит өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих хүүгийн уян хатан бодлого хэрэгжүүлэх, банкны системийн шалгуур үзүүлэлтүүдийг зохистой түвшинд байлгах", 2.2.1-д "Таван толгойн бүлэг ордыг ашиглах, Таван толгойн 450 МВТ-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВТ-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВТ-ын өргөтгөл зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх", 2.2.2-д "Таван толгой-Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэн, Зүүнбаян-Ханги, Эрдэнэт-Овоот, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж, Богд хан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх" гэж тусгасан байгаа.

Улсын Их Хурлын гишүүн миний бие дээрх зорилтуудын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг удирдлага болгон Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Үндэсний үйлдвэрлэл хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ямар арга хэмжээ хэрэгжүүлсэн, арга хэмжээний үр дүн ямар байгаа талаар;
2. Томоохон төслийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх, эдийн засгийн бодит өсөлт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих хүүгийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж чадаж байгаа эсэх;
3. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах, Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулах ажлуудыг эхлүүлсэн эсэх, эхлүүлсэн бол ямар шатандаа хэрэгжиж байгаа талаар;
4. "Тавантолгой-Гашуун сухайт", "Хөөт-Бичиг" чиглэлийн төмөр зам, "Тавантолгой-Гашуун сухайт" чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, "Шивээ хүрэн-Сэхэ" чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгах ажлуудын хөрөнгийн болон гүйцэтгэгчийн асуудал шийдэгдсэн эсэх, төслийн үйл ажиллагаа хэзээ эхлэх, ямар хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх;
5. Таван толгойн 450 МВТ-ын цахилгаан станц, Гацууртын алтны орд, Дулааны III цахилгаан станцын 250 МВТ-ын өргөтгөл, Чойбалсангийн ДЦС-ын 50 МВТ-ын өргөтгөл барих төслүүдийн явцын талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



З.НАРАНТУЯА